


Нийтлэлийг: nationalgeographic.mn

Гэрэл зургийг: AP/NASA



АНУ-ын Сан Франциско хотноо болж буй Америкийн геофизикчдийн зовлолийн ээлжит хуралдааны үеэр танилцуулсан мэдээлэл олны сонирхлыг нэлээд татаж байна. Энэ оны эхээр сар руу хооргосон NASA-гийн Эбб, Флоу хэмээх ихэр сансрын аппаратаас ирүүлсэн дэлгэрэнгүй газрын зураглалаас дэлхийн дагуулын гадаргын талаарх сонирхолтой дүр зургийг харж болохоор байгаа ажээ.

Эрдэмтдийн мэдээлж буйгаар сар нь үүсч бий болсон анхны үедээ ихээхэн бомбогдолтонд ортож байжээ. Сарны онгон гадаргын доор асар ихээр ан цав гарч, сүйдсэн гүн хэсэг нуугдаж буй нь нотлогдсон богоод ингэснээр бусад гаригууд, тэр дундаа дэлхий нь үүсэн бий болсон анхны үедээ солирт мон ихээр бомбогдүүлж байсныг илтгэж байгаа юм.

Эбб, Флоугийн илгээсэн мэдээллээс үзвэл сарны гадарга нь урьд тосоолж байснаас хамаагүй нимгэн буюу ердоо 25 милийн зузаантай аж.

Сарны таталцлын хүчийг олно нь судалж байсан ч Эбб, Флоу нь зөвхөн энэ зорилгоор хооргосон анхны аппаратууд билээ. Угаалгын машины хэмжээтэй тус хоёр аппарат нь сарны гадаргаас 35 милийн зайд тойрон эргэлдэж байгаа юм.

Энэхүү судалгааны ажил энэ сарын сүүлч буюу Эбб, Флоу хоёр сарны гадарга дээр унаж сонох хүртэл үргэлжлэнэ.